



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 17 өдөр

Дугаар А/08

Номгон

“Эрдэнэ Монгол” ХХК-ний агуулахын байршил
тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 313 дугаар тогтоолоор батлагдсан “Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэм”-ийн дагуу Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших “Эрдэнэ Монгол” ХХК-ний MV-021444 тоот тусгай зөвшөөрөл бүхий Хөндий алтны үндсэн ордын талбайд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг хавсралтаар тогтоосугай.


2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн агуулахын байнгын байршлыг газрын мэдээллийн санд хуулийн хугацаанд бүртгүүлж, агуулахад тогтоосон аюулгүйн бүсийн хил хязгаарт иргэд, аж ахуйн нэгжид газар олгохгүй байхыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Д.Алтангэрэл), Шинэжинст сумын Засаг дарга (Б.Бат-Эрдэнэ) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагаар хийлгэж хуулийн дагуу үйл ажиллагаа явуулахыг “Эрдэнэ Монгол” ХХК-ний гүйцэтгэх захирал (Петер Акерли)-д үүрэг болгосугай.

4. Тэсэрч дэлбэрэх бодисын агуулахын байнгын байршлыг мэдээллийн нэгдсэн санд хуулийн хугацаанд бүртгүүлж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Т.Хишигбаатар)-т даалгасугай.

5. Энэ захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2020 оны “Агуулахын байршил тогтоох тухай” А/92 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

642310018

Аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 1108 дугаар захирамжийн хавсралт

МV-021444 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ БҮХИЙ "ХӨНДИЙ" АЛТНЫ
ҮНДСЭН ОРДЫН ТАЛБАЙН ТЭСЭРЧ ДЭЛБЭРЭХ БОДИС,
ТЭСЭЛГЭЭНИЙ АГУУЛАХЫН БАЙНГЫН БАЙРШИЛ

Цэгийн дугаар	Сумын нэр	X	Y	Талбайн хэмжээ /м2/
1	2	3	4	5
1	Шинэжинст	4862630.940	483287.580	6538.92
2		4862731.000	483287.580	
3		4862731.000	483352.930	
4		4862630.940	483352.930	

оОо